



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/35

Хархорин сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 1, 2, 3 дугаар багт байрлах 10 нэгж талбарын 7188м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Г.Пүрэвжав, С.Батбаатар, Витафит милк ХХК, Ж.Түмэндэмбэрэл, Ч.Энхбаяр, Г.Содномсүрэн, Г.Отгонцэцэг, С.Мөнхсоёл, Б.Намжил нарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2023 оны А/29 дүгээр захирамжийн иргэн Д.Дуламсүрэнтэй холбогдох хэсэг, 2024 оны А/197 дугаар захирамжийн иргэн Д.Бямбажав, Н.Нямдаваа нартай холбогдох хэсэг, 2020 оны А/227 дугаар захирамжийн Т.Дуламсүрэнтэй холбогдох хэсэг, 2022 оны А/237 дугаар захирамжийн Ч.Болдбаатартай холбогдох хэсэг, 2018 оны А/68 дугаар захирамж, 2019 оны А/124 дүгээр захирамжийн Б.Намжилтай холбогдох хэсэг, газар эзэмших эрхийн 0000050596, 0000173428, 0000359087, 0000357972, 0000004558, 0000359505, 000642500 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ



40110011